

БАНКНЫ САЛБАРЫН ЗЭЭЛИЙН БҮТЭЦ, ЧАНАРЫН БАЙДАЛД ХИЙСЭН СУДАЛГАА

Г.Мөнхзул*, Г.Мөнхтуяа**

Хураангуй: Монгол Улсын арилжааны банкуудын 2012-2016 оны зээлийн бүтэц, чанарын байдалд дүн шинжилгээ хийж үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор харьцуулах, нэгтгэн дүгнэх, геометрийн дунджийг тооцох, экстраполяцийн аргыг ашиглан энэхүү судалгааны ажлыг хийсэн болно.

Түлхүүр үгс: зээл, зээлийн ангилал, чанаргүй зээл, өсөлтийн хурд, дундаж өсөлт

Санхүүгийн салбар нь эдийн засагт хөрөнгийн хуваарилалтыг хийдэг чухал салбар бөгөөд итгэлцэл дээр оршин тогтнодог.

Зах зээлийн харилцааны өнөө үед арилжааны банк нь санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэж, үйлдвэрлэл, дэд бүтцийг хөгжүүлэх, эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд санхүүгийн нөөцийг зүй зохистой ашиглах боломж олгодог.

Арилжааны банк нь доорх 3 төрлийн үндсэн үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

1. Сул чөлөөтэй байгаа мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, хадгалах
2. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд зээл олгож, хөрөнгө оруулалт хийх
3. Харилцагчийн төлбөр тооцоог хийж гүйцэтгэх

Арилжааны банкны үндсэн үүрэг нь сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэн хадгалж, тухайн үеийн зах зээлийн нөхцлийн дагуу тодорхой хувийн хүүтэйгээр үйлдвэрлэл, үйлчилгээний янз бүрийн салбарын бизнес эрхлэгчдэд зээл олгох явдал байна.

Сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг татан төвлөрүүлэх, зээлдүүлэх харилцааг хэрэгжүүлэхэд банкны оролцоо чухал. Иймд зээлдүүлэгчийн мөнгийг зээлдэгчид олгох зуучлагчийн үүргийг арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллагууд гүйцэтгэсээр ирсэн.

* МУИС-ийн Бизнесийн сургууль, (E-mail) zula_gt@yahoo.com

** МУИС-ийн Бизнесийн сургууль, (E-mail) munkhtuya9999@yahoo.com

Аливаа улс орны санхүүгийн системийн найдвартай байдлыг илэрхийлэхэд санхүүгийн тогтвортой байдал гэсэн үзүүлэлт чухал байр суурийг эзэлдэг.

Санхүүгийн тогтвортой байдал гэж нөөц хуваарилалт, санхүүгийн эрсдлийг удирдах зэрэг эдийн засгийн тогтолцоонууд нь эдийн засгийн өсөлт, хөгжлийг дэмжихэд чиглэсэн байх төдийгүй зах зээлийн таагүй гэнэтийн нөлөөлөл, хямралын үед ажиллах чадвартай байхыг хэлнэ.

Санхүүгийн тогтвортой байдлыг тухайн улс орны эдийн засгийн бүх талаас цогц байдлаар авч үзэх боловч санхүүгийн системийн төлбөрийн чадвар, эдийн засгийн нөөц, үр ашиг, түүний хуваарилалт, эрсдлийн удирдлага, эдийн засагт нөлөөлөх гэнэтийн таагүй гадаад нөлөөлөл болон хямралын үед санхүүгийн системийн ажиллах чадварыг илүүтэй авч үздэг.

Банкны секторын зээлийн эрсдэл, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг судлах нь өнөөгийн нөхцөлд зайлшгүй асуудлын нэг болоод байна.

Зээлийн эрсдэл гэдэг нь зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй, зээлээ хугацаанд нь төлөөгүй тохиолдолд үүсэх боломжит алдагдал юм³. Зээлийн эрсдэлд макро эдийн засгийн орчин болон микро эдийн засгийн орчны олон хүчин зүйлс нөлөөлдөг. Тухайлбал,

Макро эдийн засгийн орчин нөлөөлөл:

- Эдийн засгийн мөчлөгийн үзүүлэлтүүд (ДНБ)
- Хэрэглээний үнийн индекс буюу инфляци
- Бизнес эрхлэгчдийн санхүүгийн байдал
- Өрхийн орлого, зардал
- Гадаад хүчин зүйлс (гадаад худалдааны үзүүлэлт, гадаад валютын ханш)

Микро эдийн засгийн орчин нөлөөлөл:

- Зээлдэгчдийн үйл ажиллагааны хүчин зүйлс (Аж ахуйн нэгж байгууллага болон хувь хүний үйл ажиллагааны хүчин зүйлс)
- Банкны байгууллагын үйл ажиллагааны хүчин зүйлс

Банкуудын зээлийн чанар, түүний эргэн төлөгдөх болон эрсдэл үүсгэх нөхцөл байдал нь зээлдэгчийн үйл ажиллагааны тогтвортой байдал, төлбөрийн

³ “Банкны системийн зээлийн эрсдлийн өөрчлөлт, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс” Н.Ургамалсувд

чадвараас ихээхэн хамаардаг.

Олон улсын практикт банкнаас олгосон зээлийг хугацаа чанарыг харгалзан хэвийн ба чанаргүй зээл гэж ангилдаг байна.

Монгол банкны ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтран гаргасан журамд активын ангиллыг хугацааны болон чанарын хүчин зүйлд тулгуурлан дор дурдсанаас доошгүй тооны ангиллаар тус, тусад нь хийж, аль доогуур үнэлгээгээр эцсийн ангиллыг тогтооно.

2.1.1.1. Хэвийн;

2.1.1.2. Анхаарал хандуулах;

2.1.1.3. Чанаргүй, үүнээс:

2.1.1.3. а. Хэвийн бус;

2.1.1.3. б. Эргэлзээтэй;

2.1.1.3. в. Муу⁴

Төлөгдөх хугацаандаа байгаа бөгөөд төлбөр хариуцагч тал төлбөрийг гэрээний дагуу төлөхөд аливаа хүндрэл, эрсдэл үүсээгүй байгаа зээлийг хэвийн зээл гэсэн ангилалд хамааруулах ба төлбөр хариуцагч зээлийн үндсэн болон хүүний төлбөрөө хугацаанд төлж байгаа ч ирээдүйд төлбөр барагдуулахад хүндрэл үүсч болзошгүй зээлийг анхаарал хандуулах зээлийн ангилалд шилжүүлнэ.

Борлуулалт, ажил үйлчилгээний орлого нь хугацаандаа орж ирээгүй, зээлийн барьцаа, баталгаанд авсан хөрөнгийн үнэлгээ буурсан зэргээс шалтгаалж зээлийн төлбөр хугацаандаа хийгдээгүй зээлийг чанаргүй зээл гэнэ.⁵

Төлбөр хариуцагч үндсэн болон хүүгийн төлбөрийг гэрээнд заасан хуваарийн дагуу төлж барагдуулах нь эргэлзээтэй болсон активыг чанаргүй гэсэн ангилалд шилжүүлнэ.

Нийт активын дүнд чанаргүй активын эзлэх хувийн жин нэмэгдэх нь банкны санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлнө.

Монгол Улсын нийт арилжааны банкуудын 2012-2016 оны тайлан тэнцлийн мэдээлэлд үндэслэн зээл олголт, зээлийн эргэн төлөлт, зээлийн үлдэгдэлд судалгаа хийж, өсөлтийн хурдыг тодорхойлж үнэлэлт дүгнэлт өгөх

⁴ Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтран гаргасан 2016 оны А-336/400-р тушаалын 1-р хавсралт

⁵ "Санхүү, мөнгө зээлийн харилцаа". Д. Моломжамц. 2008 он

зорилгоор энэхүү судалгааг хийсэн болно.

Банкны салбарт 2016 оны эцсийн байдлаар нийт 14 банк 1492 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.⁶

Арилжааны банкууд 2012 онд 7,167,137.7 сая төгрөгийн зээл олгож байсан бол 2016 онд 11,293,748.3 сая төгрөгийн зээл олгосон байна. / Хавсралт 1, хүснэгт 1/

Хүснэгт 1. 2012-2016 оны зээлийн нэгтгэл (сая.төг)

	2012	2013	2014	2015	2016
Зээлийн үлдэгдлийн дүн	6,941,135.22	10,715,632.67	12,440,925.89	11,633,573.72	12,337,508.64
Олгосон зээлийн дүн	7,167,137.77	11,395,920.10	11,545,716.25	9,490,928.19	11,293,748.31
Төлөгдсөн зээлийн дүн	5,872,197.91	7,856,309.87	9,861,296.87	9,608,923.47	11,110,303.58
Чанаргүй зээл	293,295.81	564,260.39	623,937.94	822,397.94	1,047,453.74

Санхүүгийн салбарын 2014 оны 2 дугаар сараас олгох зээлийн хэмжээ тасралтгүй буурч эхэлсэн нь зээлийн багцын дийлэнх хувийг бүрдүүлдэг банкны салбарын зээлийн чанар муудсан, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал үүсэж, санхүүгийн зах зээлийн нөхцөл чангарч, эдийн засгийн идэвхжил удааширсантай холбоотой.

Нийт зээлийг салбарын ангиллаар авч үзвэл 2012 онд барилга, уул уурхай, бөөний болон жижиглэн худалдааны салбарын эзлэх хувийн жин өндөр байснаа, 2016 онд барилга, үл хөдлөх хөрөнгийн үйлчилгээ, бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарын эзлэх хувийн жин өссөн байна.

Зээл олголтын хэмжээ нэмэгдсэн хэдий ч 2012-2016 онд банкны салбарын тайлан тэнцэлд тусгагдсан нийт зээлийн дүнд чанаргүй зээлийн эзлэх хувийн жин жил ирэх тусам нэмэгдсэн байна.

⁶ Монгол улсын тогтвортой байдлын тайлан. 2016 он

Зураг 17



График 1-ээс харахад нийт зээлийн үлдэгдэлд хэвийн зээлийн үлдэгдлийн хувийн жин буурах хандлагатай байхад хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хэмжээ өсөх хандлагатай байна. Эндээс хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хэмжээ 2012 онд олгосон нийт зээлийн 5.8 хувийг эзэлж байсан бол 2016 онд 15.8 хувьд хүрсэн байна.

Чанаргүй зээлийн дүнд салбар тус бүрийн эзлэх хувийн жин ямар байдалтай байгааг тодорхойлбол:

Зураг 2



7 Хавсралт 1-д өгөгдсөн мэдээлэл үндэслэн боловсруулалт хийж тооцсон болно.

Чанаргүй зээлийн дүнд салбаруудын хувийн жинг тооцоолж үзэхэд 2012 онд барилга, худалдааны салбарын эзлэх хувийн жин их байснаа, 2013 онд уул уурхайн салбар, боловсруулах үйлдвэрт дэх хувийн жин өссөн байна. Чанаргүй зээлийн дүнд тухай салбарын эзлэх хувийн жингийн өсөлт бууралт нь тухайн салбарт олгосон зээлийн өсөлт бууралттай хамааралтай байна. 2016 онд уул уурхай, худалдааны байгууллагын чанаргүй зээлийн эзлэх хувийн жин өссөн хандлагатай байна.

Нийт чанаргүй зээлийн хэмжээ 2016 оны эцсийн байдлаар 1,047,453.7 сая төгрөгт хүрч (нийт зээлийн 8.5 хувь), өмнөх оны мөн үеэс 225,055.8 сая төгрөгөөр буюу 27.4 хувиар өссөн бол хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 899,910.3 сая төгрөгт хүрч (нийт зээлийн 7.3 хувь) 5.8 хувиар нэмэгдсэн байна.

Чанаргүй зээлийн өсөлт нь зээлийн эрсдэлийн сангийн зардлыг нэмэгдүүлснээр банкны салбарын өөрийн хөрөнгийн болон ашигт ажиллагааны үзүүлэлтэд сөргөөр нөлөөлж, зээлийн эргэн төлөлт найдваргүй болох эрсдлийг үүсгэж байна. Энэ нь тухай салбарын хувьд үйл ажиллагаа явуулахад хүндрэл үүсгэх нэг хүчин зүйл болно.

Аливаа үзүүлэлтийн өсөлтийн дундаж хурдыг экстраполяцийн аргаар тооцохдоо дараах томъёог ашиглана.

Геометр дунжийг тооцохдоо:

$$\bar{k}_{geo} = \sqrt[n]{\frac{y_n}{y_1} - 1} + 1$$

y_1 - суурь оны үзүүлэлт
 y_n - тайлант оны үзүүлэлт
 n - хугацааны тоо

Экстрапотенциал дунжийг тооцохдоо:

$$\begin{aligned} y_2 &= y_1 (1 + e^{\bar{k}_{экспон}}) \\ y_3 &= y_1 (1 + e^{2\bar{k}_{экспон}}) \\ y_n &= y_1 (1 + e^{(n-1)\bar{k}_{экспон}}) \end{aligned} \quad \bar{k}_{экспон} = \frac{\ln\left(\frac{y_n}{y_1}\right)}{(n-1)}$$

Монгол улсын нийт арилжааны банкуудын 2012-2016 онд олгосон зээл, төлөгдсөн зээл, зээлийн үлдэгдэл болон чанаргүй зээлийн үлдэгдлийн дүн тус бүрийн абсолют утгууд нь өсөх хандлагатай байгаа нь харагдаж байна. / Хүснэгт 1/

Үзүүлэлт тус бүрийн өсөлтийн дундаж хурдыг геометр дундажаар тооцоолж үзвэл:

Зээлийн үлдэгдлийн дундаж хурд:

$$K = \sqrt[4]{\frac{12,337,508,64}{6,941,135,22}} - 1 = 0,154647$$

Олгосон зээлийн дундаж хурд:

$$K = \sqrt[4]{\frac{11,293,748,31}{7,167,137,77}} - 1 = 0,1204$$

Төлөгдөж байгаа зээлийн дундаж хурд:

$$K = \sqrt[4]{\frac{11,110,303,58}{65,872,197,91}} - 1 = 0,174698$$

Чанаргүй зээлийн үлдэгдлийн дундаж хурд:

$$K = \sqrt[4]{\frac{1,047,453,74}{293,295,81}} - 1 = 0,374698$$

Дээрх тооцооллоос харахад арилжааны банкуудын нийт олгож байгаа зээлийн хурд хамгийн бага буюу 0,1204 байгаа нь арилжааны банкуудын зээлдэгчдэд олгож буй зээлийн хэмжээ буурсантай холбоотой байна. Харин нийт чанаргүй зээлийн үлдэгдлийн хурд хамгийн их буюу 0,374698 байгаа нь нийт эдийн засгийн идэвхжил саарснаас шалтгаалан банкны салбарын зээлийн чанар муудан хэвийн бус, эргэлзээтэй, муу зээлийн дүн эрчимтэй өссөнтэй холбоотой байгаа нь ажиглагдлаа.

Монгол улсын нийт арилжааны банкуудын 2017 оны зээл олголт, зээлийн эргэн төлөлт, зээлийн үлдэгдэл болон чанаргүй зээлийн үлдэгдлийн дүнг өсөлтийн дундаж хурдаар тооцоолбол:

Нийт зээлийн үлдэгдлийн дүн:

$$У\ 2017 = 6,941,135.22 * (1+0.154647)^5 = 14,245,466.07 \text{ сая. төгрөг}$$

Нийт олгох зээлийн дүн:

$$У\ 2017 = 7,167,137.77 * (1+0.1204)^5 = 12,653,517.02 \text{ сая.төгрөг}$$

Нийт төлөгдөх зээлийн дүн:

$$У\ 2017 = 5,872,197.91 * (1+0.172820)^5 = 13,030,392.60 \text{ сая.төгрөг}$$

Нийт чанаргүй зээлийн дүн:

$$У\ 2017 = 293.295.81 * (1+0.374698)^5 = 1,439,933.26 \text{ сая. төгрөг тус тус болж өсөх таамаглалтай байна.}$$

Дүгнэлт

Санхүүгийн салбарын зээлийн багцын дийлэнх хувийг бүрдүүлдэг банкны салбарын зээлийн өсөлт эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн өнөө үед арилжааны банкууд шинээр зээл олгох нь эрсдэлтэй гэж үзэн 2014 оны 2 дугаар сараас олгох зээлийн хэмжээ нь тасралтгүй буурч эхэлсэн бөгөөд 2016 оны сүүлийн хагас жилээс өсөх хандлагатай болсон.

2012-2016 онд банкны салбарын тайлан тэнцэлд тусгагдсан нийт зээлийн дүнд чанаргүй зээлийн эзлэх хувийн жин жил ирэх тусам нэмэгдсээр байна.

Чанаргүй зээлийн дүнд салбаруудын хувийн жинг тооцоолж үзэхэд 2012 онд барилга, худалдааны салбарын эзлэх хувийн жин их байснаа, 2013 онд уул уурхайн салбар, боловсруулах үйлдвэрт дэх хувийн жин өссөн байна. Чанаргүй зээлийн дүнд тухай салбарын эзлэх хувийн жингийн өсөлт бууралт нь тухайн салбарт олгосон зээлийн өсөлт бууралттай хамааралтай байна. 2016 онд уул уурхай, худалдааны байгууллагын чанаргүй зээлийн эзлэх хувийн жин өссөн хандлагатай байна.

Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хэмжээ 2012 онд олгосон нийт зээлийн 5.8 хувийг эзэлж байсан бол 2016 онд 15.8 хувьд хүрсэн байна.

Чанаргүй зээлийн өсөлт нь зээлийн эрсдэлийн сангийн зардлыг нэмэгдүүлж, зээлийн эргэн төлөлт найдваргүй болох эрсдлийг бий болгож байна. Энэ нь тухайн салбарын хувьд үйл ажиллагаа явуулахад хүндрэл үүсгэх нэг хүчин зүйл болно.

Өсөлтийн дундаж хурдыг тооцоолоход арилжааны банкуудын нийт олгож байгаа зээлийн хурд хамгийн бага буюу 0,1204, харин нийт чанаргүй зээлийн үлдэгдлийн хурд хамгийн их буюу 0,374698 байгаа нь ажиглагдлаа. Нийт арилжааны банкуудын 2017 оны зээл олголт, зээлийн эргэн төлөлт, зээлийн үлдэгдэл болон чанаргүй зээлийн үлдэгдлийн дүнг өсөлтийн дундаж хурдаар тооцоолоход нийт олгох зээлийн дүн 12,653,517.02 сая. төгрөг, чанаргүй зээлийн дүн 1,439,933.26 сая. төгрөг, хүрэхээр байна.

Судалгааны үр дүнгээс банкны салбарт зээлийн эрсдлийг бууруулах, чанаргүй зээлийн хэмжээг багасгах үүднээс дараах арга хэмжээнүүдийн авч хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд:

- Монгол Улсын гадаад болон дотоод өрийн дарамтыг бууруулах
- Монгол банкны зүгээс арилжааны банкуудын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах
- Банкны салбарын тогтвортой байдлыг хангах хууль эрх зүйн орчныг сайжруулах
- Олон улсын дэвшилтэт арга туршлагыг судалж, нэвтрүүлэх
- Муу зээлийн багцыг борлуулах хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх
- Эдийн засгийн нөхцөл байдлыг сайжруулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлэх
- Зээлдэгчдийн судалгааг чанаржуулах
- Ажилтнуудын ур чадварыг сайжруулж, ёс зүйг төлөвшүүлэх
- Зээлийн эрсдлээс хамгаалах талаар тодорхой бодлого хэрэгжүүлэх
- Тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах

Ашигласан материал:

1. Моломжамц,Д, Санхүү, мөнгө зээлийн харилцаа, Улаанбаатар, 2008 он
2. Насанбаяр,Б, Цэрэнтогоо,А, Арилжааны банкны үйл ажиллагааны үндэс 2007
3. Насанбаяр,Б, Банкны нягтлан бодох бүртгэл, Улаанбаатар, 2004
4. Сийлэгмаа,О, Банкны нягтлан бодох бүртгэл, Улаанбаатар, 2011
5. Андросов,А.М, Менатеп-Информ, Финансовая отчетность банка, 1995
6. Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтран гаргасан 2016 оны А-336/400-р тушаалын 1-р хавсралт
7. Монгол банкны ерөнхийлөгч, сангийн сайдын хамтарсан 2015.02.06-ны А-35/20-р тушаалаар батлагдсан “Банкны нягтлан бодох бүртгэлийн багц материал”
8. Монгол улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлан, 2016

9. Төрийн банк 2012-2016 оны тайлан тэнцэл www.statebank.mn
10. Худалдаа хөгжлийн банк 2012-2016 оны тайлан тэнцэл www.tdbm.mn
11. Хаан банк 2012-2016 оны тайлан тэнцэл www.khanbank.com
12. Голомт банк 2012-2016 оны тайлан тэнцэл www.golomtbank.com
13. Капитал банк 2012-2016 оны тайлан тэнцэл <https://capitalbank.mn/>
14. Капитрон банк 2012-2016 оны тайлан тэнцэл <https://www.capitronbank.mn/>
15. Хас банк 2012-2016 оны тайлан тэнцэл <https://www.хасbank.mn/>
16. Улаанбаатар хотын банк 2012-2016 оны тайлан тэнцэл www.ubcбанк.mn
17. Үндэсний хөрөнгө оруулалтын банк 2012-2016 оны тайлан тэнцэл <https://www.nibank.mn>
18. Тээвэр хөгжлийн банк 2012-2016 оны тайлан тэнцэл www.transbank.mn
19. Ариг банк 2012-2016 оны тайлан тэнцэл <https://www.arigbank.mn>
20. Чингис хаан банк 2012-2016 оны тайлан тэнцэл www.ckbank.mn
21. Богд банк 2012-2016 оны тайлан тэнцэл www.bogdбанк.com
22. <http://mongolbank.mn>
23. https://en.wikipedia.org/wiki/Credit_risk
24. <https://www.fool.com/knowledge-center>

		Нийт арилжааны банкны зээлийн мэдээлэл /сая.төг.төгрөг./									
		2012	2013	2014	2015	2016	2012	2013	2014	2015	2016
1	Бүх банкуудын зээлийн үлдэгдэл Зээлийн бүтэц дүн Хугацаандаа байгаа зээл Хугацаа хэтэрсэн зээл Цанцруй зээл	6,941,135.22 6,538,338.98 109,480.44 293,295.81	10,715,632.67 10,034,225.67 117,146.61 364,260.39	12,440,925.89 11,549,186.55 267,801.39 623,937.94	11,633,573.72 9,953,281.33 857,894.45 822,397.94	12,337,508.64 10,390,144.58 899,910.32 1,047,453.74	100.00 93.64 1.09 5.27	100.00 92.83 2.15 5.02	100.00 92.83 2.15 5.02	100.00 85.56 7.37 7.07	100.00 84.22 7.29 8.49
2	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилат, ан агнуур	186,272.78	226,988.58	316,834.44	241,298.94	282,881.27	2.68	2.12	2.55	2.07	2.29
3	Ула уурхай, олборлолт	798,461.48	1,328,438.25	1,129,537.67	1,163,609.90	761,703.65	11.50	12.40	9.08	10.00	6.17
4	Боловсруулах үйлдвэрлэл	797,602.44	1,085,049.97	1,317,763.24	1,285,940.82	1,294,342.72	11.49	10.13	10.59	11.05	10.49
5	Цахилгаан, уур, цахилгаан, уур, агааржуулах хангамж	24,749.51	97,754.78	64,011.10	48,785.36	113,552.71	0.36	0.91	0.51	0.42	0.92
6	Усан хангамж; бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	3,679.37	4,988.85	13,069.16	11,879.16	9,677.97	0.05	0.05	0.11	0.10	0.08
7	Барилга	899,892.99	1,457,204.87	1,647,369.65	1,526,770.17	1,333,773.20	12.96	13.60	13.24	13.12	10.81
8	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотортэй зэвсгэр үйлчилгээ	1,141,812.24	1,746,285.84	1,803,763.67	1,678,437.74	1,741,979.98	16.45	16.30	14.50	14.43	14.12
9	Тээвэр ба агууламж үйл ажиллагаа	215,072.68	196,160.31	174,815.33	133,685.04	155,882.91	3.10	1.83	1.41	1.15	1.26
10	Байр, сууд болон хоол хүнсээр үйлдэх үйл ажиллагаа	130,056.47	176,994.38	216,953.80	240,674.37	250,751.43	1.87	1.65	1.74	2.07	2.03
11	Мэдээлэл, холбоо	38,232.81	46,259.70	118,098.68	90,252.42	83,687.60	0.55	0.43	0.95	0.78	0.68
12	Санхүүгийн болон давтгалын үйл ажиллагаа	41,402.70	58,013.06	232,479.38	240,680.23	464,859.15	0.60	0.54	1.87	2.07	3.77
13	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	970,473.61	1,764,737.52	2,218,508.29	1,525,305.86	1,968,573.16	13.98	16.47	17.83	13.11	15.96
14	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон технологийн үйл ажиллагаа	2,493.94	2,291.50	25,806.07	12,565.96	10,391.49	0.04	0.02	0.21	0.11	0.08
15	Захирааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	56,525.40	88,273.46	61,768.10	138,442.58	138,869.41	0.81	0.82	0.50	1.19	1.13
16	Төрийн удирдлага ба баглан хангамж үйлчилгээ, албан журмын нийгмийн хамгаалал	8,115.57	6,825.28	2,832.06	1,605.45	2,242.52	0.12	0.06	0.02	0.01	0.02
17	Боловсрол	34,427.25	49,180.44	40,501.29	86,405.25	132,450.29	0.50	0.46	0.33	0.74	1.07
18	Хүний зургаа мөнд ба нийгмийн үйл ажиллагаа	39,805.50	70,264.26	73,482.40	74,065.38	77,976.83	0.57	0.66	0.59	0.64	0.63
19	Бусад	1,532,038.48	2,309,921.62	2,983,331.55	3,133,151.10	3,513,912.34	22.36	21.56	23.98	26.93	28.48
1	Бүх банкуудын олсон зээл	7,167,137.77	11,395,920.10	11,545,716.25	9,490,928.19	11,293,748.31	2012	2013	2014	2015	2016
2	Зээлийн бүтэц дүн	154,316.03	223,077.27	320,964.54	236,389.41	184,725.06	100.00	100.00	100.00	100.00	100.00
3	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилат, ан агнуур	623,046.30	930,629.93	512,339.67	387,889.52	419,728.08	2.15	1.96	2.78	2.49	1.64
4	Ула уурхай, олборлолт	596,656.54	759,097.10	898,582.19	592,057.57	774,603.73	8.69	8.17	4.44	4.09	3.72
	Боловсруулах үйлдвэрлэл						8.32	6.66	7.78	6.24	6.86

5	Цамгатан, хий, уур, агааржуулахтын хангамж Усан хангамж; бохир ус, хог-хагдлын менежмент болон цөөрлөх үйл ажиллагаа	17,904.98	99,686.13	58,238.24	42,505.86	194,935.41	0.25	0.87	0.50	0.45	1.73
6	Усан хангамж; бохир ус, хог-хагдлын менежмент болон цөөрлөх үйл ажиллагаа	3,482.24	5,005.85	16,773.11	8,446.30	3,349.10	0.05	0.04	0.15	0.09	0.03
7	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, моторшклагийн засвар үйлчилгээ	635,883.53	1,419,978.14	1,293,715.94	885,875.06	678,436.25	8.87	12.46	11.21	9.33	6.01
8	Ус, хог-хагдлын менежмент болон цөөрлөх үйл ажиллагаа	1,697,273.15	2,398,125.35	2,284,987.02	1,928,581.10	2,173,028.79	23.68	21.04	19.79	20.32	19.24
9	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	142,861.28	180,681.56	186,590.12	98,650.95	156,215.73	1.99	1.59	1.62	1.04	1.38
10	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	104,391.93	146,385.57	130,525.63	122,451.63	167,660.30	1.46	1.28	1.13	1.29	1.48
11	Мэдээлэл, холбоо	22,354.76	37,399.70	137,702.13	86,456.73	76,207.90	0.31	0.33	1.19	0.91	0.67
12	Санхүүгийн болон давтгалын үйл ажиллагаа	117,660.96	123,482.67	290,068.53	175,663.61	413,307.40	1.64	1.08	2.51	1.85	3.66
13	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	380,546.59	1,248,729.18	1,286,316.97	922,043.00	876,512.62	5.31	10.96	11.14	9.71	7.76
14	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	2,028.24	5,181.69	13,695.64	23,763.00	3,328.82	0.03	0.05	0.12	0.25	0.03
15	Захирагчын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	117,451.29	139,411.37	40,421.15	177,378.19	90,790.30	1.64	1.22	0.35	1.87	0.80
16	Төрийн удирдлага ба баглан хамгаалах үйлчилгээ, албан журмын нийгмийн хамгаалах	11,327.50	12,050.13	5,247.48	2,493.44	2,914.19	0.16	0.11	0.05	0.03	0.03
17	Боловсрол	26,850.72	30,746.61	22,747.01	23,162.11	53,559.17	0.37	0.27	0.20	0.24	0.47
18	Хүний зургууд мөнд ба нийгмийн үйл ажиллагаа	35,062.95	60,310.62	31,598.54	40,171.91	39,504.11	0.49	0.53	0.27	0.42	0.35
19	Бусад	2,478,038.59	3,575,941.23	4,015,202.33	3,736,948.78	4,984,941.34	34.58	31.38	34.78	39.37	44.14
1	Бүх банкнаар төмрөсөн зээл	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
1	Зээлийн булчлалт	5,872,197.91	7,856,309.87	9,861,296.87	9,608,923.47	11,110,303.58	100.00	100.00	100.00	100.00	100.00
2	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	127,073.01	176,355.86	236,259.52	233,042.24	194,543.47	2.16	2.24	2.40	2.43	1.75
3	Үйл үүсдэй, олборлолт	529,061.37	559,709.15	764,180.16	388,286.84	871,901.52	9.01	7.42	7.75	4.04	7.85
4	Бодисруулах үйлдвэрлэл	433,037.93	611,495.21	666,377.73	648,992.41	855,121.94	7.37	7.78	6.76	6.75	7.70
5	Цамгатан, хий, уур, агааржуулахтын хангамж	12,306.81	31,456.97	92,327.68	60,746.34	168,233.63	0.21	0.40	0.94	0.63	1.51
6	Усан хангамж; бохир ус, хог-хагдлын менежмент болон цөөрлөх үйл ажиллагаа	9,707.80	4,174.97	9,390.44	9,080.13	5,588.53	0.17	0.05	0.10	0.09	0.05
7	Байдал	434,647.79	792,929.13	1,040,045.81	1,005,610.23	929,189.72	7.40	10.09	10.55	10.47	8.36
8	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, моторшклагийн засвар үйлчилгээ	1,495,856.82	1,834,033.45	2,339,008.31	2,077,075.56	2,228,035.06	25.47	23.34	23.72	21.62	20.05
9	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	131,955.66	221,460.39	221,330.97	146,505.22	143,669.45	2.25	2.82	2.24	1.52	1.29

10	Байр, сууд болон хоол хүнсээр үйлдэх үйл ажиллагаа	90,658.01	106,620.40	170,461.33	121,852.20	175,106.55	1.54	1.36	1.73	1.27	1.58
11	Мэдээлэл харуулах үйл ажиллагаа	24,148.28	37,694.21	167,159.32	117,215.37	131,021.80	0.41	0.48	1.70	1.22	1.18
12	Санхүүгийн болон давтгалын үйл ажиллагаа	144,328.73	107,717.58	180,123.22	176,046.55	316,839.08	2.46	1.37	1.83	1.83	2.85
13	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	213,789.71	474,182.27	509,244.20	760,209.77	435,330.65	3.64	6.04	5.16	7.91	3.92
14	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	2,063.95	4,942.62	7,465.93	36,990.18	6,949.79	0.04	0.06	0.08	0.38	0.06
15	Захирагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	150,864.28	111,601.11	101,644.16	103,113.39	95,044.73	2.57	1.42	1.03	1.07	0.86
16	Төрийн удирдлага ба бусад хамгаалах үйлчилгээ, албан хаагчдын нийгмийн хамгаалах үйл ажиллагаа	15,215.98	12,944.83	8,484.18	3,529.66	2,790.64	0.26	0.16	0.09	0.04	0.03
17	Боловсрол	31,830.94	34,159.89	41,324.02	29,484.71	38,082.11	0.34	0.43	0.42	0.31	0.34
18	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	27,049.71	30,098.90	39,228.05	39,941.17	39,894.74	0.46	0.38	0.40	0.42	0.36
19	Бусад	1,998,600.93	2,704,732.93	3,267,241.82	3,651,201.49	4,472,960.17	34.03	34.43	33.13	38.00	40.26

Хавсралт 2

Нийт арилжааны банкны зээлийн үлдэгдлийн өсөлт

		Хувиар			
	Үзүүлэлт	2013	2014	2015	2016
1	Зээлийн бүгд дүн	1.54	1.16	0.94	1.06
	Хугацаандаа байгаа зээл	1.53	1.15	0.86	1.04
	Хугацаа хэтэрсэн зээл	1.07	2.29	3.20	1.05
	Чанаргүй зээл	1.68	1.11	0.92	0.92
2	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1.22	1.40	0.76	1.17
3	Уул уурхай, олборлолт	1.66	0.85	1.03	0.65
4	Боловсруулах үйлдвэрлэл	1.36	1.21	0.98	1.01
5	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	3.95	0.65	0.76	2.33
6	Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	1.36	2.62	0.91	0.81
7	Барилга	1.62	1.13	0.93	0.87
8	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	1.53	1.03	0.93	1.04
9	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0.91	0.89	0.76	1.17
10	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	1.36	1.23	1.11	1.04
11	Мэдээлэл, холбоо	1.21	2.55	0.76	0.93
12	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1.40	4.01	1.04	1.93
13	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1.82	1.26	0.69	1.29
14	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	0.92	11.26	0.49	0.83
15	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1.56	0.70	2.24	1.00
16	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	0.84	0.41	0.57	1.40
17	Боловсрол	1.43	0.82	2.13	1.53
18	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	1.77	1.05	1.01	1.05
19	Бусад	1.49	1.29	1.05	1.12

Нийт арилжааны банкны олгосон зээлийн өсөлт

		Хувиар			
	Үзүүлэлт	2013	2014	2015	2016
1	Эзэлийн бүгд дүн	1.59	1.01	0.82	1.19
2	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1.45	1.44	0.74	0.78
3	Уул уурхай, олборлолт	1.49	0.55	0.76	1.08
4	Боловсруулах үйлдвэрлэл	1.27	1.18	0.66	1.31
5	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	5.57	0.58	0.73	4.59
6	Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	1.44	3.35	0.50	0.40
7	Барилга	2.23	0.91	0.68	0.77
8	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	1.41	0.95	0.84	1.13
9	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1.26	1.03	0.53	1.58
10	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	1.40	0.89	0.94	1.37
11	Мэдээлэл, холбоо	1.67	3.68	0.63	0.88
12	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1.05	2.35	0.61	2.35
13	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	3.28	1.03	0.72	0.95
14	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	2.55	2.64	1.74	0.14
15	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1.19	0.29	4.39	0.51
16	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	1.06	0.44	0.48	1.17
17	Боловсрол	1.15	0.74	1.02	2.31
18	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	1.72	0.52	1.27	0.98
19	Бусад	1.44	1.12	0.93	1.33

Хавсралт 4

Нийт арилжааны банкны төлөгдсөн зээлийн өсөлт

		Хувиар			
	Үзүүлэлт	2013	2014	2015	2016
1	Эзэлийн бүгд дүн	1.34	1.26	0.97	1.16
2	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1.39	1.34	0.99	0.83
3	Уул уурхай, олборлолт	1.06	1.37	0.51	2.25
4	Боловсруулах үйлдвэрлэл	1.41	1.09	0.97	1.32
5	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	2.56	2.94	0.66	2.77
6	Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0.43	2.25	0.97	0.62
7	Барилга	1.82	1.31	0.97	0.92
8	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	1.23	1.28	0.89	1.07
9	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1.68	1.00	0.66	0.98
10	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	1.18	1.60	0.71	1.44
11	Мэдээлэл, холбоо	1.56	4.43	0.70	1.12
12	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	0.75	1.67	0.98	1.80
13	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	2.22	1.07	1.49	0.57
14	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	2.39	1.51	4.95	0.19
15	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0.74	0.91	1.01	0.92
16	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	0.85	0.66	0.42	0.79
17	Боловсрол	1.07	1.21	0.71	1.29
18	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	1.11	1.30	1.02	1.00
19	Бусад	1.35	1.21	1.12	1.23